



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 10

Мөрөн сум

Даваацэрэнгийн Ган-Эрдэнийг бие даан
нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, 19 дүгээр зүйлийн 19.1, 31 дүгээр зүйлийн 31.3, 31.3.7, 31.3.9, 31.9, 32 дугаар зүйлийн 32.1.4, 32.2, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 40 дүгээр зүйлийн 40.2.5, 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Сонгуулийн хорооноос ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 21 дүгээр тойрогт бие даан нэр дэвшигчээр бүртгүүлэхээр баримт бичиг ирүүлсэн Даваацэрэнгийн Ган-Эрдэнэ нь иргэний үнэмлэхний хуулбар, төрийн аудитын дээд байгууллагаар хянуулсан бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлтгүй, баримт бичгийн бүрдэл дутуу ирүүлсэн байх тул Д.Ган-Эрдэнийг Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 21 дүгээр тойрогт бие даан нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсугай.

2. Захиргааны актын хувийн хэрэг бүрдүүлж, тогтоолыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 21 дүгээр тойрогос бие даан нэр дэвшигчээр бүртгүүлэхээр баримт бичиг ирүүлсэн Д.Ган-Эрдэнэд 2020 оны 09 дүгээр сарын 14-ний дотор мэдэгдэх буюу баталгаат шуудангаар хүргүүлэхийг аймгийн сонгуулийн хорооны нарийн бичгийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

3. Хуулийн хугацаанд баримт бичгийнхээ зөрчлийг арилган дахин бүртгүүлэх тухай хүсэлтээ аймгийн сонгуулийн хороонд ирүүлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

4. Энэхүү тогтоолыг эс зөвшөөрвөл тогтоолыг мэдэгдсэн буюу гардан авснаас хойш 7 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Х.ГАН-ОЧИР

Р.МАШБАТ